**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**
**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Аудитын код: ХОА-2022/80/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Ховд хот<br>2023 он | Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70433061<br>Цахим хаяг: khovd@audit.gov.mn<br>Аудитор: У.Батчимэг<br>Утас: 88094175<br>Цахим хаяг:batchimeg@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..........

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..........5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..........11

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..........11

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..........12

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..........12

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..........12

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..........13

**3.5.1 Төсвийн төлөвлөлт** ..........13

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл** ..........13

**3.5.3 Нэмэлт төсөв** ..........

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн** ..........

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..........13

**4.1 Ерөнхий зүйл** ..........14

**4.2 Материаллаг байдал** ..........14

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..........14

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..........14

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..........15

**4.5 Завсрын аудитын талаар** 2022 онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг хянасан. ..........15

**4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн** ..........15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..........15

5.1 Залруулсан алдаа ..........16

5.2 Төлбөрийн акт ..........16

5.3 Зөвлөмж ..........17

6. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл ..........18


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ОНӨ | Орон нутгийн өмчийн газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодолго зохицуулалтын газар |

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.25 № 2/86

танай ____________-ны №____________-т

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тус байгууллага нь өмнөх он болон тайлант онд үүссэн өр төлбөрийг нэмэлт санхүүжилтийн данснаас 13.6 сая төгрөгийг шийдүүлэн өр төлбөрийг барагдуулан ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Орон нутгийн өмчийн газар нь Аймгийн засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ, Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 4 зорилтын хүрээнд 4 арга хэмжээ, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд 8 зорилтын хүрээнд 8 арга хэмжээ, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээний хүрээнд 2 зорилтын хүрээнд 2 арга хэмжээ нийт 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг 97.6 хувьтай гүйцэтгэн ажиллажээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.25 № 2/86

танай ____________-ны №____________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заавры дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тус байгууллага нь өмнөх он болон тайлант онд үүссэн өр төлбөрийг нэмэлт санхүүжилтийн данснаас 13.6 сая төгрөгийг шийдүүлэн өр төлбөрийг барагдуулан ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Орон нутгийн өмчийн газар нь Аймгийн засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ, Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 4 зорилтын хүрээнд 4 арга хэмжээ, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд 8 зорилтын хүрээнд 8 арга хэмжээ, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээний хүрээнд 2 зорилтын хүрээнд 2 арга хэмжээ нийт 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг 97.6 хувьтай гүйцэтгэн ажиллажээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,638,050.00** | **4,638,050.00** |
| **33** | **АВЛАГА** | 1,555,671.00 | 1,555,671.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,232,819.00 | 1,232,819.00 |
| **335** | **Бусад авлага** | 322,852.00 | 322,852.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 322,852.00 | 322,852.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 3,082,379.00 | 3,082,379.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 3,082,379.00 | 3,082,379.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 670,100.00 | 670,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,412,279.00 | 2,412,279.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,615,108,315.42** | **5,854,167,424.58** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 6,615,108,315.42 | 5,854,167,424.58 |
| **392** | **Биет хөрөнгө** | 6,614,936,940.38 | 5,854,110,299.50 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 10,589,103,491.00 | 10,589,103,491.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (5,233,710,066.04) | (5,983,699,850.99) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 28,500,000.00 | 28,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (26,520,834.00) | (28,500,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 217,163,883.00 | 219,835,918.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (178,409,003.72) | (188,665,006.05) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 16,445,029.00 | 16,445,029.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,547,297.86) | (10,821,020.46) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 1,211,841,739.00 | 1,211,841,739.00 |
| 39217 | Ном | 70,000.00 | 70,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 171,375.04 | 57,125.08 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 457,000.00 | 457,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (285,624.96) | (399,874.92) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **6,619,746,365.42** | **5,858,805,474.58** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **7,840,369.99** | **426,201.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 7,840,369.99 | 426,201.00 |
| **413** | **Өглөг** | 7,840,369.99 | 426,201.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 7,840,369.99 | 426,201.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,611,905,995.43** | **5,858,379,273.58** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 6,611,905,995.43 | 5,858,379,273.58 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 6,611,905,995.43 | 5,858,379,273.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 6,611,905,995.43 | 6,611,905,995.43 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (753,526,721.85) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **6,619,746,365.42** | **5,858,805,474.58** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 194,930,372.00 | 341,132,841.85 |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 16,954,166.00 | 6,342,035.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 16,954,166.00 | 6,342,035.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 0.00 | 4,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос сан хүүжих | 0.00 | 4,000,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 16,954,166.00 | 2,342,035.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 177,976,206.00 | 334,790,806.85 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 34,202,306.00 | 128,906,206.85 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,000,000.00 | 13,708,272.24 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 29,202,306.00 | 115,197,934.61 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 143,773,900.00 | 205,884,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 143,773,900.00 | 205,884,600.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 945,660,132.88 | 1,094,659,563.70 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 945,660,132.88 | 1,094,659,563.70 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 916,458,986.88 | 984,965,429.09 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 87,238,262.00 | 141,961,854.00 |
| 210101 | Үндсэн цалин | 77,561,006.00 | 110,267,271.55 |
| 210102 | Нэмэгдэл | 7,633,703.00 | 22,671,789.45 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,043,553.00 | 3,459,565.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 1,095,364.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 4,467,864.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 11,459,606.54 | 18,776,817.86 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,168,845.24 | 12,803,042.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 872,382.62 | 1,506,238.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 697,906.10 | 1,198,270.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 156,406.60 | 286,412.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,564,065.98 | 2,982,853.34 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,500,000.00 | 20,915,109.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,500,000.00 | 915,109.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,377,260.00 | 8,930,201.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,874,370.00 | 3,812,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,540,160.00 | 3,297,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 926,730.00 | 1,641,201.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 36,000.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0.00 | 180,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 200,000.00 | 847,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 200,000.00 | 847,300.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 2,297,200.00 | 6,242,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,297,200.00 | 6,242,500.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгэ эний төлбөр, хураамж** | 1,731,500.00 | 22,327,091.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг а жил үйлчилгээний төлбөр хураамж | 1,137,000.00 | 21,613,091.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогт оох | 125,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0.00 | 125,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 0.00 | 69,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 30,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 469,500.00 | 430,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчил гээний хураамж | 0.00 | 60,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 780,655,158.34 | 764,964,556.23 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 544,830.39 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 806,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 780,655,158.34 | 763,612,925.84 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29,201,146.00 | 109,694,134.61 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000.00 | 500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуу лал | 1,000,000.00 | 500,000.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захи рагчдад олгох татаас, санхүүжилт** | 28,201,146.00 | 109,194,134.61 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 388,800.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилж үүлэг | 28,201,146.00 | 108,805,334.61 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | -750,729,760.88 | -753,526,721.85 |
| VI | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | -750,729,760.88 | -753,526,721.85 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 177,976,206.00 | 338,790,806.85 |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 0.00 | 4,000,000.00 |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 0.00 | 4,000,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 0.00 | 4,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүж их | 0.00 | 4,000,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 177,976,206.00 | 334,790,806.85 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,202,306.00 | 128,906,206.85 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,000,000.00 | 13,708,272.24 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 29,202,306.00 | 115,197,934.61 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **143,773,900.00** | **205,884,600.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 143,773,900.00 | 205,884,600.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **177,976,206.00** | **338,460,806.85** |
| 299990 | Устгал | 0.00 | 0.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **177,976,206.00** | **338,460,806.85** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **148,775,060.00** | **228,766,672.24** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **79,986,900.00** | **137,664,200.00** |
| 210101 | Үндсэн цалин | 58,612,341.00 | 108,270,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 15,204,913.00 | 26,877,800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,019,318.00 | 2,515,600.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4,150,328.00 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **10,798,800.00** | **16,819,199.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,475,400.00 | 11,701,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 952,200.00 | 1,101,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 611,500.00 | 1,250,696.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 160,000.00 | 249,057.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,599,700.00 | 2,516,645.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **22,500,000.00** | **20,915,100.00** |
| 210302 | Түлш, халаалт | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,500,000.00 | 915,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,787,360.00** | **8,630,901.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,090,400.00 | 2,798,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,540,160.00 | 3,714,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 870,800.00 | 1,641,201.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 36,000.00 | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 250,000.00 | 416,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **200,000.00** | **797,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 200,000.00 | 797,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,297,200.00** | **4,652,900.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,297,200.00 | 4,652,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,827,000.00** | **23,599,300.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,137,000.00 | 22,997,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 125,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0.00 | 153,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 0.00 | 90,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 30,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 550,000.00 | 220,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15,000.00 | 108,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **20,377,800.00** | **15,687,572.24** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,377,800.00 | 14,120,872.24 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 1,566,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **29,201,146.00** | **109,694,134.61** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,000,000.00** | **500,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **28,201,146.00** | **109,194,134.61** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 388,800.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 28,201,146.00 | 108,805,334.61 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **0.00** | **330,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **0.00** | **330,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **330,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **0.00** | **330,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.00 | 330,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **0.00** | **-330,000.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | 7,362,635,756.31 | 7,362,635,756.31 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | **7,362,635,756.31** | 7,362,635,756.31 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (750,729,760.88) | (750,729,760.88) |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | **6,611,905,995.43** | 6,611,905,995.43 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | - | - | **6,611,905,995.43** | 6,611,905,995.43 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | | |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | **6,611,905,995.43** | 6,611,905,995.43 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (753,526,721.85) | (753,526,721.85) |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | **5,858,379,273.58** | 5,858,379,273.58 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|

| Эдийн засгийн ангилал | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 209995800.00 | 209495800.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 209995800.00 | 209495800.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 209494600.00 | 208995800.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 137664200.00 | 137664200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 108270800.00 | 108270800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 26877800.00 | 26877800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2515600.00 | 2515600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17208000.00 | 16819199.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,701,500.00 | 11701500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,101,300.00 | 1101300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,376,600.00 | 1250696.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 275,300.00 | 249057.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2753300.00 | 2516645.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20915100.00 | 20915100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20000000.00 | 20000000.00 |
| 210304 | Байрны түрээс | 915100.00 | 915100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8740900.00 | 8630901.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2798400.00 | 2798400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3714600.00 | 3714600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,751,200.00 | 1,641,201.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,000.00 | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 416,700.00 | 416,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 797,500.00 | 797,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 797,500.00 | 797,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,652,900.00 | 4,652,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,652,900.00 | 4,652,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,499,300.00 | 17,499,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,567,500.00 | 16,567,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 153,800.00 | 153,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,000.00 | 90,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000.00 | 30,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 550,000.00 | 550,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 108,000.00 | 108,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,016,700.00 | 2,016,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 450,000.00 | 450,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,566,700.00 | 1,566,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 501,200.00 | 500,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 501,200.00 | 500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 501,200.00 | 500,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 213,972,600.00 | 209,884,600.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 209,972,600.00 | 205,884,600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 209,972,600.00 | 205,884,600.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,000,000.00 | 4,000,000.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 128,906,206.9 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 128,906,206.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 20,100,872.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,430,000.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,670,872.2 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 108,805,334.6 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 128,906,206.9 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,708,272.2 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 115,197,934.6 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн өмчийн газар нь "Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн болон орон нутгийн өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт" -ыг хэрэгжүүлэх гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Тухайн онд Аймгийн санхүүгийн хяналт аудитын албанаас 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн зөвлөмж, чиглэл өгч ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна. Дараах тогтоолуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай "
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай"
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орон нутгийн өмчийн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтгүй гэж үзлээ.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орон нутгийн өмчийн газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 760.9 сая төгрөгөөр буюу 11.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/сая.төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 1.5 | 1.5 | 0 |
| Бараа материал | 3.1 | 3.1 | 0 |
| Үндсэн хөрөнгө | 6615.1 | 5854.1 | -761 |
| **Нийт хөрөнгө** | **6619.7** | **5858.7** | **-761** |

| Өр төлбөр | 7.8 | 0.4 | -7.4 |
|---|---|---|---|
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 6611.9 | 5858.4 | -753.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **6619.7** | **5858.8** | **-753.5** |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Өмнөх онд аймгийн Орон нутгийн өмчийн газрын авлага 1.5 сая төгрөг байсан тайлант онд авлага барагдуулан ажиллаагүй.
- ✓ Бараа материалын үлдэгдэл өмнөх онд 3.1 сая төгрөг байсан бөгөөд тайлант оны эцсийн үлдэгдэл хэвээр байна.
- ✓ Өр төлбөрийн хувьд өмнөх онд үүссэн өглөгийг тайлант онд 7.4 сая төгрөгөөр барагдуулан, тайлант онд 0.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2022 оны орон нутгийн төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 205.8 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 4.0 сая төгрөг, бүгд 209.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж тайлант оны эхэнд 209.8 сая төгрөгөөр баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 205.8 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 4.0 сая төгрөгийг зарцуулан 0.3 сая төгрөгийг орон нутгийн дансанд төвлөрүүлэн ажиллажээ.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/сая. төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70106/80101-ОН-ын гүйцэтгэх засаглалын уди | 209.3 | 209.3 | - | 100.0 |
| 2 | 70106/80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 0.5 | 0.5 | - | 100.0 |
| | **ДҮН** | **209.8** | **209.8** | - | **100** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор У.Батчимэг 2023 оны 02 дугаар сарын 25-ноос 02 дугаар сарын 28–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12 албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 971.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 14.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10.9 сая төгрөгөөр тогтоосон байсныг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.5 хувиар буюу 14.7 сая төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 11.0 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Орон нутгийн өмчийн газар нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцастай холбоотой заалтууд хамаарах зардал санхүүжүүлээгүй байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувд тус байгууллага нь 2022 онд 6.2 сая төгрөгийн албан томилолтын зардлыг Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын тооллогын ажилд зарцуулан ажилласан байна.

15 дугаар зүйлийн 15.1.7-д байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах гэсэн заалтыг зөрчсөн байна.

14 дүгээр зүйлд заасан зөрчлийн дэлгэрэнгүйг тайлангийн 5-д харуулав.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн 6.4.5-д заасны дагуу тайлант онд 165 ажил гүйлгээг мэдээлэн 14 ажил гүйлгээг мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2.2 сая төгрөгийн 2 албан шаардлага, 4 зөвлөмж өгөгдөж хэрэгжилтийг 91.3 хувьтай хэрэгжүүлэн ажиллажээ.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | | Биелэлт | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - |
| Албан шаардлага | 2 | 2.2 | 2 | 2.2 | 100.0 |
| Зөвлөмж | 4 | 15.1 | 3.0 | 13.6 | 90.1 |
| **Нийт дүн** | **6** | **17.3** | **5.0** | **15.8** | 91.3 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулж байгаа дэнчингийн орлого болон түрээсийн орлогыг нэг бүрчлэн үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулсан алдаа байхгүй.

Аудитаар нийт 5.3 сая төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 0.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 1.5 сая төгрөгийн албан шаардлага 3 зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1** Байгууллагын хэрэгцээнд шаардлагагүй хүнсний материал худалдан авч зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4-д төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ, Төрийн хэмнэлтийн тухайн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах гэсэн заалттай нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.2 Албан шаардлага**

***5.2.1* Өглөг авлагатай холбоотой**

Орон нутгийн өмчийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд он дамжсан насжилт өндөртэй 1.5 сая төгрөгийн авлага барагдаагүй, он дамжин бүртгэгдэж өмнөх оны аудитын зөвлөмж хэрэгжээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**5.3 Зөвлөмж**

**5.3.1 Бараа материалтай холбоотой**

**Илрүүлэлт:** Бараа материалыг ЭАЭЗ аргаар зарлагадаагүй, оны эцсийн үлдэгдэл тоолж баталгаажуулаагүй байгаа зөрчил нь Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалын НХМаягт БМ-9-д "бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалган хүлээж авна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** : Бараа материалыг ЭАЭЗ аргаар зарлагадан, оны эцсийн үлдэгдэл тоолж баталгаажуулан ажиллаж хэвших.

**5.3.2 Үндсэн хөрөнгөтэй холбоотой**

**Илрүүлэлт:** Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 90 ширхэг 185.8 сая төгрөгийн хөрөнгө байна. Цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, үндсэн хөрөнгийг шинж чанараас нь хамааруулан бусад хангамжийн материал, үндсэн хөрөнгийн дансаар ангилан бүртгэх гэсэн заалттай нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоолоор батлагдсан 7.1. Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

**5.3.3 Цалин хөлс, нэмэгдэл урамшууллалтай холбоотой**

**Илрүүлэлт:** Нийт ажилчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлж дүгнэн үр дүнгийн урамшуулал олгохгүй байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1 "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно, 2.2 Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна гэсэн заалттай нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нийт ажилчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан улирал тутамд дүгнэж ажлын үр дүнгээр урамшуулал олгож хэвших.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Он дамжсан насжилт өндөртэй авлагыг барагдуулан ажиллаагүй, өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаагүй байна. | 1 | 1.6 | | | 1 | 1.6 | | | | - | - | - |
| Бараа материалыг ЭАЭЗ аргаар зарлагадаагүй, оны эцсийн үлдэгдэл тоолж баталгаажуулаагүй, зөрүүтэй илэрхийлсэн | 1 | 3.0 | | | | | 1 | 3.0 | | | | |
| Нийт ажилчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан улирал тутамд дүгнэж ажлын үр дүнгээр урамшуулал олгож хэвших | 1 | | | | | | 1 | | | | | |
| Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 90 ширхэг 185.8 сая төгрөгийн хөрөнгө байна. Цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, үндсэн хөрөнгийг шинж чанараас нь хамааруулан бусад хангамжийн материал, үндсэн хөрөнгийн дансаар ангилан бүртгэж хэвших | 1 | | | | | | 1 | | | | | |
| Дүн | 4 | 4.6 | | | 1 | 1.6 | 3 | 3.0 | | | | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байгууллагын хэрэгцээнд шаардлагагүй хүнсний материал худалдан авч зарцуулсан | 1 | 0.7 | 1 | 0.7 | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:** **Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:** **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АУДИТОР:** **У.БАТЧИМЭГ**